

Нийслэл Улаанбаатар хотыг Захирах яам

1937 оны 2 дугаар сарын 13-энд Улаанбаатар хотын тэргүүлэгчид, СнЗ-ийн хамтарсан 4/2 дугаар тогтоолоор хотын захиргааг өөрчлөн “Нийслэл Улаанбаатар хотыг захирах яам” болгохоор тогтоосон байна.

1937 оны 2 сарын 5-анд СнЗ-ийн тогтоолоор Улаанбаатар хотын Захиргааны эрхийг өргөтгөн яамны эрх хэмжээнд хүргэж, хотыг захирах яам хэмээн нэрлэж яамны даргыг СнЗ-ийн жинхэнэ гишүүн болгожээ.

1937 оны 05 дугаар сарын 4-өд Улсын бага хурлын тэргүүлэгчдийн хурлаар Нийслэл Улаанбаатар хотыг захирах яамны дүрмийг баталсан ба үндсэн хуулийн дагуу нийслэл хотын яам нь хотын ба хороодын хурлаар батлагдахаар заажээ.

СнЗ, Улсын бага хуралд захирагдах ба сайд нь СнЗ-ийн гишүүн байхаас гадна хотыг захирах яам нь 9 тэргүүлэгч, 3 орлогчтойгоо хотын хурлаас сонгогддог байсан.

1937 оны 02 дугаар сарын 13-анд Сайд нарын Зөвлөлийн 2 дугаар хурал, Улаанбаатар хотын Тэргүүлэгчдийн 4 дүгээр тогтоолоор 02 зүйлээр Улаанбаатар хотын захиргааг өөрчлөн "Улаанбаатар хотыг захирах яам" болгосон.

1937-4-23-анд Сайд нарын Зөвлөлийн 12 дугаар хурлын 4-р зүйлээр Нийслэл Улаанбаатар хотыг захирах яамны дүрмийг баталжээ. Мөн яам нь Сайд нарын /Зөвлөлийн гишүүн байна гээд дотоод байгуулалтыг /-Хотын байдлыг сайжруулах хэлтэс, энэ хэлтэст харьяалагдах-Орон сууцны тасаг-Түлээ модны бэлтгэлийн газар-Захирах тушаах хэлтэс-Санхүүгийн хэлтэс-Цэргийн хэлтэс-Ардын соёл боловсруулах хэлтэстэй байна гэжээ. Мөн яамны шууд захиргааны газрууд:-Амгалан-баатар хотын захиргаа-Хороо, хориодын захиргаанд-Хотын өнчин ядуусыг тэтгэх газар-Хүн эмнэлгийн салбар газрууд Тусгай дүрмээр хотын хэмжээнд дээр ажиллах газрууд-Хотын прокурорууд-Хотын шүүх таслах газар-Хотын хоршооны байгууллагууд, Барьцаалан зээлдүүлэх ламфортын газар-Хотын доторх артель, нэгдэл, үйлдвэр, мал эмнэлгийн ажил явуулах удирдлага нөлөөг үзүүлнэ гэжээ.

1937-5-4-энд УБХ-ын тэргүүлэгчдийн хурлаар нийслэл Улаанбаатар хотыг захирах яамны дүрмийг баталжээ. Мөн дүрмийн 4-р бүлэгт Хот захирах яамны дотоод зохион байгуулалт нь-Хот сайжруулах хэлтэс /орон сууцны тасаг, түлээ мод бэлтгэх газартай/-Захирах тушаах хэлтэс-Санхүүгийн хэлтэст-Цэргийн хэлтэс-Ардын боловсролын хэлтэс-Пи-оны /паспортын/ хэлтсүүдтэй байх. Мөн шууд захирагдах орон нутгийн чанартай газрууд нь Амгалан-баатар хотын захиргаа, хороо хорьтын захиргаа хотын өнчин ядуусын тэтгэх газар, хүн эмнэлгийн салбарууд гэж заажээ.

1932 оны 8 дугаар сарын 22-онд Сайд нарын Зөвлөлийн 9 дугаар хурлын 3 дугаар зүйлээр Төв аймаг, Улаанбаатар хотын захиргааг салгаж байгуулахаар шийдвэрлэсэн юм.

1938 оны 04 дүгээр сарын 1-энд СнЗ-ийн хурлаар хот сайжруулах комиссын төслийг хэлэлцээд баталсан.

1939 оны 3 сард улсын 22 дугаар бага хурлын тогтоолоор “хотыг захирах яам” хэмээн нэрлэхийг “Улаанбаатар хотын захиргаа” хэмээн нэрлэх болсон.

Шинэчлэгдсэн дүрэмд Бусад зүйлийг заахдаа харьяат хотыг захирах, дээд газраас гаргасан хууль, дүрэм, тогтоол, тушаалыг биелүүлэх хотын дотор журам, байдлыг сахиулах, хотын доторх аж ахуй, үйлдвэр, худалдаа, соёлын байгууллагыг удирдаж, зохистой хөгжүүлэх, ард түмний соёл, бичгийн үсгийн мэдлэгийг дээшлүүлэх, ариун цэвэр, эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг шууд авч явуулана.

Мөн улсын бага хурлын тэргүүлэгчид /Сайд нарын Зөвлөл/ олон яамд зэрэг төв байгууллагуудаас дагаж шийтгүүлэн байгаа хууль дүрэм, тогтоол тушаалуудад нийцүүлэн хотын хэмжээнд дээр ерөнхий удирдлага өгч харьяалагдах албан газруудын ажилд хяналт

тавих,ард иргэдийн эрх үүргийг хамгаалах, хот орчныг хөгжүүлэх талаар холбогдсон нэлээд шинэ үүрэг заасан байна